

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР




САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/99/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.




## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	20
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХК	Хувьцаат компани
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БГ	Боловсролын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар





**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 72

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг □ онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 99,900.0 мянган төгрөгийн цахим анги, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 29,843.0 мянган төгрөгийн дуу шуумны тоног төхөөрөмж, 13,589.2 мянган төгрөгийн ухаалаг самбар, Боловсролын газрын хөрөнгө оруулалтаар 1,513.7 мянган төгрөгийн ном, 2,177.0 мянган төгрөг программ хангамж, Шарын гол сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар охидын ерөөний тохижилтод 6,632.7 мянган төгрөг, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 5,418.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 2,521,713.3 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 47.4 хувиар өссөн байна.

### **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго 12 зорилтын хүрээнд 149 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.3 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР






## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>499,173,506.80</b>	<b>438,828,924.28</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>353,405,219.63</b>	<b>291,539,003.11</b>
312	Банканд байгаа бэлэн мөнгө	353,405,219.63	291,539,003.11
3121	төгрөг	353,405,219.63	291,539,003.11
31211	Төрийн сангийн харилцах	353,405,219.63	291,539,003.11
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>145,768,287.17</b>	<b>147,289,921.17</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,651,301.00</b>	<b>1,242,430.00</b>
3511	Тусгай зориулалттай материал		
3513	Эм боох материал	1,651,301.00	1,242,430.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>144,116,986.17</b>	<b>146,047,491.17</b>
35410	Бичиг хэргийн материал	3,804,710.00	2,700,360.00
35420	Аж ахуйн материал	104,938,399.17	102,022,139.17
3545	Барилгын засварын материал	3,753,600.00	4,554,800.00
3546	Хүнсний материал	5,742,158.00	3,608,436.00
35470	Бусад хангамжийн материал	25,878,119.00	33,161,756.00
36	НӨӨЦ БАРАА		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,169,017,017.32</b>	<b>6,148,708,411.36</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,169,017,017.32</b>	<b>6,148,708,411.36</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>6,106,458,600.45</b>	<b>6,086,920,002.51</b>
39201	Барилга, байгууламж орон сууц	6,475,364,113.13	6,475,364,113.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(957,052,345.40)	(1,156,838,346.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	526,711,367.84	683,975,651.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158,911,156.50)	(182,621,855.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	224,446,802.98	236,983,630.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(126,284,441.93)	(88,276,407.50)
39209	Зам гүүрийн байгууламж	87,109,727.21	87,109,727.21
39210	Хуримтлагдсан элэгдэл	(26,824,000.20)	(32,188,800.24)
39217	Ном	61,898,533.32	63,412,289.52
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>62,558,416.87</b>	<b>61,788,408.85</b>
39301	Программ хангамж	10,932,300.00	13,109,358.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,485,883.13)	(8,432,949.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	57,112,000.00	57,112,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,668,190,524.12</b>	<b>6,587,537,335.64</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,668,190,524.12</b>	<b>6,587,537,335.64</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,668,190,524.12	6,587,537,335.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	946,771,565.43	946,771,565.43
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн	946,771,565.43	946,771,565.43





512	Хуримтлагдсан үр дүн	656,098,819.01	575,445,630.53
51210	Өмнөх үеийн үр дүн	656,098,819.01	656,098,819.01
51220	Тайлант үеийн үр дүн		(80,653,188.48)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,065,320,139.68	5,065,320,139.68
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,668,190,524.12</b>	<b>6,587,537,335.64</b>






## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,246,505,670.44</b>	<b>3,995,073,949.22</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>294,834,970.44</b>	<b>347,888,649.22</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>294,834,970.44</b>	<b>347,888,649.22</b>
<b>120004</b>	Төсөвт байгууллагын өөрийн орлого	16,972,328.00	8,793,740.00
<b>1200041</b>	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,227,300.00	6,434,600.00
<b>1200042</b>	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,745,028.00	2,359,140.00
<b>1200045</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		75,797,343.02
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	244,185,874.44	159,164,129.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	33,676,768.00	104,133,437.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,951,670,700.00</b>	<b>3,647,185,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,567,937,900.00</b>	<b>3,227,025,300.00</b>
<b>131001</b>	<b>Урсгалт үйл ажиллагааны санхүүжилт</b>	<b>2,567,937,900.00</b>	<b>3,227,025,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>383,732,800.00</b>	<b>420,160,000.00</b>
132001	Урсгалт үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	383,732,800.00	420,160,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,963,141,940.75</b>	<b>4,075,727,137.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,963,141,940.75</b>	<b>4,075,727,137.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,791,269,626.50</b>	<b>3,889,894,479.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,710,246,344.73</b>	<b>2,521,713,328.26</b>
210101	Үндсэн цалин	1,192,144,363.78	1,573,694,098.92
210102	Нэмэгдэл	442,600,419.35	827,040,149.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	75,501,561.60	120,979,080.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>216,069,795.11</b>	<b>314,500,932.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	148,691,560.16	217,486,721.43
210202	Тэтгэмжийн даатгал	17,507,680.27	25,594,107.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,762,143.98	13,433,592.35
210204	Ажилгүйдлийн даатгал	3,273,216.20	11,595,657.53
210205	Эрүүл мэндийн даатгал	32,835,194.50	46,390,853.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>366,361,457.75</b>	<b>399,614,782.29</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,844,876.73	17,131,131.79
210302	Түлш, халаалт	310,410,346.95	343,254,466.60
210303	Цэвэр, бохир ус	38,106,234.07	39,229,183.90
210304	байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,607,543.40</b>	<b>34,783,890.00</b>

7

ХТ054300 1010000








### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,968,643,028.00</b>	<b>3,655,979,040.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>16,972,328.00</b>	<b>27,793,740.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>16,972,328.00</b>	<b>27,793,740.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>16,972,328.00</b>	<b>27,793,740.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,227,300.00	6,434,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,745,028.00	21,359,140.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,951,670,700.00</b>	<b>3,628,185,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,567,937,900.00</b>	<b>3,208,025,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,567,937,900.00	3,208,025,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>383,732,800.00</b>	<b>420,160,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	383,732,800.00	420,160,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,619,700,472.84</b>	<b>3,618,461,256.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,619,700,472.84</b>	<b>3,618,461,256.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,447,828,158.59</b>	<b>3,432,628,598.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>1,710,246,344.73</b>	<b>2,521,713,328.26</b>
210101	Үндсэн цалин	1,192,144,363.78	1,573,694,098.92
210102	Нэмэгдэл	442,600,419.35	827,040,149.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	75,501,561.60	120,979,080.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>216,069,795.11</b>	<b>314,500,932.22</b>
210201	Тэтгэврийн даатгалын	148,691,560.16	217,486,721.43
210202	Тэтгэмжийн даатгалын	17,507,680.27	25,594,107.71
210203	ҮОМШӨ-ий даатгалын	13,762,143.98	13,433,592.35
210204	Ажилгүйдлийн даатгалын	3,273,216.20	11,595,657.53
210205	Эрүүл мэндийн даатгалын	32,835,194.50	46,390,853.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>366,361,457.75</b>	<b>399,614,782.29</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,844,876.73	17,131,131.79
210302	Түлш, халаалт	310,410,346.95	343,254,466.60
210303	Цэвэр, бохир ус	38,106,234.07	39,229,183.90
210304	байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,830,295.00</b>	<b>32,851,135.00</b>
210502	Хоол хүнс	34,830,295.00	32,851,135.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>18,181,508.00</b>	<b>20,327,800.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл		










2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуригтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
S01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	946,771,565.43	5,065,320,139.68	372,735,089.32	-	6,384,826,794.43
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					-
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
S07	Тайлант үеийн үр дүн			283,363,729.69		283,363,729.69
S08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	946,771,565.43	5,065,320,139.68	656,098,819.01	-	6,668,190,524.12
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					-
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			(80,653,188.48)		(80,653,188.48)
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	946,771,565.43	5,065,320,139.68	575,445,630.53	-	6,587,537,335.64







## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>4,023,202,600.00</b>	<b>3,715,268,698.81</b>	<b>(307,933,901.19)</b>	<b>92.3%</b>
21	Урсгал зардлын дүн	4,023,202,600.00	3,615,884,698.81	(407,317,901.19)	89.9%
<b>210</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>3,825,031,500.00</b>	<b>3,432,628,598.81</b>	<b>(392,402,901.19)</b>	<b>89.7%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,689,776,400.00</b>	<b>2,521,713,328.26</b>	<b>(168,063,071.74)</b>	<b>93.8%</b>
210101	Үндсэн цалин	1,771,575,500.00	1,573,694,098.92	(197,881,401.08)	88.8%
210102	Нэмэгдэл	821,254,000.00	827,040,149.34	5,786,149.34	100.7%
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	0.0%
210104	Урамшуулал	96,946,900.00	120,979,080.00	24,032,180.00	124.8%
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	-	-	0.0%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>336,222,300.00</b>	<b>314,500,932.22</b>	<b>(21,721,367.78)</b>	<b>93.5%</b>
210201	Тэтгэврийн даатгал	228,631,000.00	217,486,721.43	(11,144,278.57)	95.1%
210202	Тэтгэмжийн даатгал	26,897,800.00	25,594,107.71	(1,303,692.29)	95.2%
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,449,000.00	13,433,592.35	(15,407.65)	99.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	13,449,000.00	11,595,657.53	(1,853,342.47)	86.2%
210205	ЭМД-ын хураамж	53,795,500.00	46,390,853.20	(7,404,646.80)	86.2%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>422,416,400.00</b>	<b>399,614,782.29</b>	<b>(22,801,617.71)</b>	<b>94.6%</b>
210301	Гэрэл, цахилгаан	23,738,800.00	17,131,131.79	(6,607,668.21)	72.2%
210302	Түлш, халаалт	331,134,700.00	343,254,466.60	12,119,766.60	103.7%
210303	Цэвэр, бохир ус	67,542,900.00	39,229,183.90	(28,313,716.10)	58.1%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>57,222,900.00</b>	<b>32,851,135.00</b>	<b>(24,371,765.00)</b>	<b>57.4%</b>
210501	Эм	-	-	-	0.0%
210502	Хоол хүнс	57,222,900.00	32,851,135.00	(24,371,765.00)	57.4%
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	0.0%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,327,800.00</b>	<b>20,327,800.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
210604	Урсгал засвар	20,327,800.00	20,327,800.00	-	100.0%
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	0.0%
210702	Дотоод томилолт	-	-	-	0.0%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>74,215,000.00</b>	<b>36,702,001.04</b>	<b>(37,512,998.96)</b>	<b>49.5%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,434,600.00	6,434,600.00	-	100.0%
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	67,780,400.00	30,267,401.04	(37,512,998.96)	44.7%
210807	Газрын төлбөр	-	-	-	0.0%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>224,850,700.00</b>	<b>106,918,620.00</b>	<b>(117,932,080.00)</b>	<b>47.6%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,572,800.00	78,353,620.00	(117,219,180.00)	40.1%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,277,900.00	28,565,000.00	(712,900.00)	97.6%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>198,171,100.00</b>	<b>183,256,100.00</b>	<b>(14,915,000.00)</b>	<b>92.5%</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг	-	-	-	0.0%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>198,171,100.00</b>	<b>183,256,100.00</b>	<b>(14,915,000.00)</b>	<b>92.5%</b>





213205	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	150,594,500.00	135,679,500.00	(14,915,000.00)	90.1%
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			-	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	47,576,600.00	47,576,600.00	-	100.0%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-	-	0.0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	0.0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	0.0%
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>99,384,000.00</b>	<b>99,384,000.00</b>	<b>0.0%</b>
	Дотоод эх үүсвэрээр			-	0.0%
	Тоног төхөөрөмж		65,371,200.00	65,371,200.00	0.0%
	Бусад хөрөнгө		34,012,800.00	34,012,800.00	0.0%
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,023,202,600.00</b>	<b>3,653,402,482.29</b>	<b>(369,800,117.71)</b>	<b>90.8%</b>
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,208,025,300.00</b>	<b>3,208,025,300.00</b>	-	<b>100.0%</b>
131001	Улсын төсвөөс	3,208,025,300.00	3,208,025,300.00	-	100.0%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				0.0%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			-	0.0%
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>440,416,400.00</b>	<b>417,583,442.29</b>	<b>(22,832,957.71)</b>	<b>94.8%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	440,416,400.00	417,583,442.29	(22,832,957.71)	94.8%
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>				
120004	<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>374,760,900.00</b>	<b>27,793,740.00</b>	<b>(346,967,160.00)</b>	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,434,600.00	6,434,600.00	-	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,327,800.00	21,359,140.00		
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	344,998,500.00			
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		353,405,219.63		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		291,539,003.11		
1	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
2	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100.0%
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0%
4	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	100.00	96.00	(4.00)	96.0%
5	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
6	Гүйцэтгэх ажилтан	78.00	74.00	(4.00)	94.9%
7	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	-	100.0%



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургууль нь "Гоё сургууль болгоё" гэсэн зорилготойгоор хүүхэд бүрийн оролцоонд тулгуурласан "хүссэн орчин, хүссэн боловсрол, хүссэн хөгжил" чанарыг эрхэмлэн зохион байгуулан ханган ажиллаж байна.

#### Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын "Аргачлал, зардлын норматив батлах тухай" 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.


Дархан Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.


Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.





Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80,653.2 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/


Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	353,405.2	291,539.0	(61,866.2)
Авлага	-	-	-
Бараа материал	145,768.3	147,289.9	1,521.6
Үндсэн хөрөнгө	6,169,017.0	6,148,708.4	(20,308.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,668,190.5</b>	<b>6,587,537.3</b>	<b>(80,653.2)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,668,190.5	6,587,537.3	(80,653.2)
			-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,668,190.5</b>	<b>6,587,537.3</b>	<b>(80,653.2)</b>

Тайлант онд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэл 291,539.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 147,289.9 мянган төгрөг болж 1,521.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 120,704.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Шарын гол сумын ИТХ-ын 2024 оны 12 тоот тогтоолоор нийгмийн хариуцлагын хүрээнд Шарын гол ХК-аас спорт заалны засварт 60,000.0 мянган төгрөгийн засварын материал, БЕГ-аас 7,283.6 мянган төгрөгийн түрээсийн ном, Шарын гол сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр охидын өрөөний тохижилтод 2,679.8 мянган төгрөг, урлаг заалны засварт 15,000.0 мянган төгрөг, Дархан-Уул аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн суудлын санхүүжилтээр урлаг заалны засварт 18,620.0 мянган төгрөгийн барилгын материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд үйл ажиллагаанд 211,074.3 мянган төгрөгийн материалыг зарцуулж, захирлын 2024 оны А/28 тоот тушаалаар 12,242.0 мянган төгрөгийн бараа материал акталсан зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,148,708.4 мянган төгрөг болж 20,308.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 65,371.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 34,012.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/450 тоот тушаалаар цахим анги хөтөлбөрөөр 99,900.0 мянган төгрөг, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/491 тоот тушаалаар 29,843.0 мянган төгрөгийн дуу шуумны тоног төхөөрөмж, БГ-аас 1,513.7 мянган төгрөгийн ном, 2,177.0 мянган төгрөг программ хангамж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/86 тоот тушаалаар 13,589.2 мянган төгрөгийн ухаалаг самбар, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр охидын өрөөний тохижилтод 6,632.7 мянган төгрөг, БЕГ-аас 5,418.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн үнэ төлбөргүйгээр хүлээн авч, ОНӨГ-ын даргын 2024 оны А/35 тоот тушаалаар анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгийг 75,797.3 мянган төгрөгөөр дахин үнэлж, 354,654.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,587,537.3 мянган төгрөг болж 80,653.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.



### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,066,804.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 498,711.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,565,516.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 3,208,025.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 440,416.4 мянган төгрөг буюу нийт 3,648,441.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,208,025.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 440,416.4 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 344,998.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 29,762.4 мянган төгрөг нийт 4,023,202.6 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 420,160.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 417,583.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 2,576.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, туслах үйл ажиллагааны 27,793.7 мянган төгрөгийн орлогын зарцуулж, улсын төсвөөс 3,208,025.3 мянган төгрөгийн санхүүжилт, өмнөх оны үлдэгдлээс 61,866.2 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 291,539.0 мянган төгрөг үлдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,715,268.7 мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 307,933.9 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71802-Ерөнхий боловсрол олгох</b>	<b>4,023,202.6</b>	<b>3,715,268.7</b>	<b>(307,933.9)</b>	<b>92.3%</b>
1.1	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	442,744.2	419,942.6	(22,801.6)	94.8%
1.2	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	7,319.5	7,319.2	(0.3)	100.0%
1.3	80233- Хүүхэд хамгаалал	7,165.6	7,165.6		
1.4	80312- Сургалт семинар	4,879.7	4,500.0	(379.7)	92.2%
1.5	81605-Эрүүл мэндийг зардал	9,836.1	2,560.0	(7,276.1)	26.0%
1.6	81801- Үдийн цай хөтөлбөр	150,594.5	135,679.5	(14,915.0)	90.1%
1.7	81806-Дотуур байрны үйлчилгээ	213,496.6	188,100.4	(25,396.2)	88.1%
1.8	81816-Хүүхдэд ээлтэй орчин	54,315.9	54,250.8	(65.1)	99.9%
1.9	81823- Багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	23,766.0	17,795.7	(5,970.3)	74.9%

4

1.10	81834- Боловсролын стандарт сургалт	2,891,981.9	2,670,519.1	(221,462.8)	92.3%
1.1	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	176,571.2	175,468.7	(1,102.5)	99.4%
1.1	81848-Сурах бичгийн түрээс	6,434.6	6,434.6	-	100.0%
1.1	81875 - Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	13,096.8	6,532.5	(6,564.3)	49.9%
1.1	83603-нэмэлт-дээд шатны төсвийн	21,000.0	19,000.0	(2,000.0)	90.5%
Нийт дүн		<b>4,023,202.6</b>	<b>3,715,268.7</b>	<b>(307,933.9)</b>	<b>92.3%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус сургууль нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 74 ажилтан, үйлчлэх 21 ажилтан буюу нийт 96 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 6,434.6 мянган төгрөг, 210901- Бараа үйлчилгээний бусад зардалд 78,535.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 186,120.2 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогч ирээгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.


### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайланд онд тус сургуулийн эрхлэгчийн 2024 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/02 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үнэлгээний хороо байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нээлттэй нэг тендер, харьцуулалттай нэг тендер шалгаруулалт, шууд худалдан авалтаар арван гурав буюу нийт 186,120.2 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг байршуулж, мэдээллийг цаг тухай бүрд нь тайлагнасан.

Тус нээлттэй тендер 1 удаагийн шалгаруулалтаар “Оргин бадрах” ХХК шалгарч 2024/02-11 тоот гэрээ байгуулсан ба харьцуулалтын 2 удаагийн тендер шалгаруулсан боловч оролцогч оролцоогүй байна.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын бараа ажил, үйлчилгээний төлбөр тооцоо, зардлын данс болон Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 19 тоот албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,963,141.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,631.40 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**


Дархан Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2,249.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1,141.4 мянган төгрөг 3 актын биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	3	1,141.40	3	1,141.40	100%
Зөвлөмж	1	2,249.40	1	2,249.40	100%
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>3,390.80</b>	<b>4</b>	<b>3,390.80</b>	

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал


Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан 2,702,104.5 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 505,920.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 93,638.9 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл буурч төсвийн гүйцэтгэл 92.3% хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,000.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд Боловсрол, ерөнхий газрын санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, Дархан-Уул аймгийн ИТХ-ын санхүүжилтээр 9,000.0 мянган төгрөг буюу нийт

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



19,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвийн урсгал санхүүжилтээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим” 5.1.4. “үнэн зөв байх” заалт, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлого санхүүжилтээр бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 2,732.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэн тул төсөвт буцаан төвлөрүүлэх 416.0 мянган төгрөгийн акт, 2,316.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

## **5.1 Төлбөрийн акт**

**5.1.1 Илрүүлэлт:** Төрийн албанаас чөлөөлөгдөж өндөр тэтгэвэр тогтоолгосны дараа манаачаар ажиллаж байгаа Х.Сэлэнгэд төрийн албан хаагчийн нэгэн адил 360.0 мянган төгрөгийн хөдөө, орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон нь Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 07 тоот зөвлөмжийн 8 дугаар заалтад “Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр чөлөөлөгдсөн хүнийг төрийн албанд сонгогддоогоос бусад үндсэн албан тушаалд томилон ажиллуулж болохгүй. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно” гэж заасантай нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоов.

**5.1.2 Илрүүлэлт:** Сахилгын шийтгэл ногдуулсан багш Пүрэвхүүхэнд 2024 оны 4 дүгээр сард 56.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123.8-т “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрөөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А10/9 тоот “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан “Сургууль, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх” гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.


## **5.2 Албан шаардлага**

Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан сургуулийн захирлын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж, 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

## **5.3 Зөвлөмж**

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/




Тайлангийн 4.2.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ




## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайланд онд туслах үйл ажиллагааны 19,000.0 мянган төгрөгийн орлогыг улсын төсвийн урсгал санхүүжилтээр бүртгэж тайлагнасныг аудитын явцад залруулав.	1	19,000.0	-	-	1	19,000.0	1	19,000.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>19,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>19,000.0</b>	<b>1</b>	<b>19,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Х:Сэлэнгэд төрийн албан хаагчийн нэгэн адил 360.0 мянган төгрөгийн хөдөө, орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон байна.	1	360.0	1	360.0								
Сахилгын шийтгэл ногдуулсан багш Пүрэвхүүхэнд 2024 оны 4 дүгээр сард 56.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.	1	56.0	1	56.0								
Тус сургуулийн захирал Б.Батбаярыг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	2,316.0	1	2,316.0								



Дүн	3	2,732.0	2	416.0	1	2,316.0	-	-	-	-
-----	---	---------	---	-------	---	---------	---	---	---	---

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус сургууль нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>

